



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

доды оны ес сарын дг өдөр

Дугаар А/97

Улаанбаатар хот

Мал, амьтны гоц халдварт шүлхий  
өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын  
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/165 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/591 дүгээр захирамж, Нийслэлийн мал эмнэлгийн газрын даргын 2024 оны А/49 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Багахангай дүүргийн нутаг дэвсгэр дэх шүлхий өвчинд мэдрэмтгий мал, амьтны вакцины дархлааны хугацаа дуусаж байгаа тул ээлжит дархлаажуулалтын ажлыг 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн дотор шуурхай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

2. Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад тус дүүргийн өвчинд мэдрэмтгий нийт 3000 толгой мал, амьтныг вакцинжуулалтад бүрэн хамруулж ажиллахыг Мал эмнэлэг үйлчилгээний нэгж "ЦЭФ" трейд ХХК (А.Цэрэндагва)-д, вакцинжуулалт хийгдэх товлосон хугацаанд, малчдад зар хүргэж, мал, амьтнаа бэлэн байлгах ажлыг зохион байгуулж ажиллахыг хороодын Засаг дарга (Н.Нямзав, Б.Батзориг) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардагдах зүү тариур, халдвар хамгаалал, хөдөлмөр хамгаалал, шатах тослох материал, ажиллах хүн хүчний зардлыг хавсралтаар баталсугай.

4. Гоц халдварт өвчний дархлаажуулалтад шаардагдах 2.022.700 (Хоёр сая хорин хоёр мянга долоон зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, заавар зөвлөмж өгч, мэргэжил арга зүйн болон нэгдсэн удирдлагаар ханган, санхүүгийн тайланг үйл ажиллагаа зохион байгуулж дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор ирүүлэхийг Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

АЖИЛ/2024 он ажил/захирамж

1123200269

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны ... сарын ...-ны өдрийн ... дугаар  
захирамжийн хавсралт



МАЛ АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВАКЦИНЖУУЛАЛТ  
БОЛОН ХЯНАЛТЫН АЖИЛД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

1. Шатахуун, зүү тариур, халдвар хамгаалал, холбоо, зарлан мэдээллийн зардал

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Шатахуун А-92	л	190	2410	457,900.00
2	Тариур	ш	500	400	200,000.00
3	Зүү	ш	500	700	350,000.00
4	Нэг удаагийн маск	ш	100	200	20,000.00
5	Нэг удаагийн малгай	ш	100	200	20,000.00
6	Нэг удаагийн бээлий	Хайрцаг	2	35000	70,000.00
7	Цэнхэр спирт	л	2	6000	12,000.00
8	Шатахуун А-92 /вакцины татан авалт болон вакцинжуулалтын ажлын гүйцэтгэлийн үеийн хяналт шалгалтад/	л	80	2410	192,800.00
<b>ДҮН</b>					<b>1,322,700.00</b>

2. Ажиллах хүчний зардал

№	Ажиллах хүч	Тоо	Нэг өдрийн цалин	Нэг өдрийн нийт цалин	Ажиллах хоног	Нийт ажлын хөлс
1	Туслах ажилтан	2	50000	100000	7	700,000.00
<b>ДҮН</b>						<b>700,000.00</b>
<b>НИЙТ ДҮН</b>						<b>2,022,700</b>